МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
1 дүгээр хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 51 02, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddic.gov.mn,
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025.02.28 № 03/501

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ӨНӨРБАЯР ТАНАА

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлангийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 31 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАН-ОД

АТА12939 6806252 9024070591

1525030612

Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 02 дугаар сарын
28-ны өдрийн 03/521 дугаар албан бичгийн хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, эх үүсвэр /сая төгрөг/ | Зарцуулсан төсөв, эх үүсвэр /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь | Хугацаа /I-IV/ улирал | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЯАМНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1.1. ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ, РАДИО ДАВТАМЖ, САНСРЫН ХОЛБОО, ИННОВАЦЫН БОДЛОГЫГ ТӨЛӨВЛӨХ, САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ | | | | | | | | | | |
| | Зорилт 1. Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана. | 15.0 Урсгал зардал | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо<br>Батлсан баримт бичгийн тоо<br>Зөвлөмж, тайлангийн тоо<br>Арга хэмжээний тоо | - | 4<br>4<br>2<br>10 | Хүргүүлсэн баримт бичгийн тоо 2<br>Боловсруулсан баримт бичгийн тоо 3<br>Батлсан баримт бичгийн тоо 1<br>Арга хэмжээний тоо 24 | 80.5 | I-IV | БТГ |
| 1 | Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн төслийн тоо | Харилцаа холбооны тухай хууль 1995 онд батлагдаж, 9 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. | 1 | 1.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төсөл болон дагалдаж гарах 6 хуулийн төслийг байгууллагын цахим хуудаст 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 02 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд байршуулж, олон нийтээс санал авсан.<br>2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 15.8 дахь хэсэгт заасны дагуу Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдаар батлуулахаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/163 дугаартай, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулахаар 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/291 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 1/849 дугаартай албан бичгээр үзэл баримтлалын төслийг батлахаас татгалзаж буцаасан.<br>3.Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг салбарын харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд болон холбогдох бусад байгууллагын төлөөллийг хамруулан 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт мэдээлэл, хрилцаа холбооны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 70 гаруй төлөөлөл оролцож, хуулийн төсөлтэй холбоотой санал, зөвлөмжийг өгсөн.<br>4.Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Үзэл баримтлалын төслийг буцаасантай холбогдуулан ЦХИХХ-ны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/45 дугаар тушаалаар Харилцаа холбооны тухай хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. | 90 | I | БТГ |
| 2 | Арга хэмжээ 1.2. Интернэтийн дундын холболтын журам батална. | - | - | Батлсан баримт бичгийн тоо | - | 1 | Интернэтийн дундын холболтын журам боловсруулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулж, 2024 оны 09 дүгээр сарын 05, 18-ны өдөр ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан хийх ажлын төлөвлөгөө болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцсэн. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Интернэтийн дундын холболтын өнөөгийн нөхцөл байдлын талаар судалгаа хийсэн. Технологийн хөгжил, дотоодын интернэтийн харилцан холболтын өнөөгийн нөхцөл байдлаас шалтгаалж, журмын төслийг зөвхөн Дата төв дээрх Монголын интернэтийн харилцан холболтын төвийн үйл ажиллагааг зохицуулахаар бус нийт дотоодын интернэт урсгалыг зохицуулах (commercial байдлаар зохион байгуулах) хүрээнд тодорхой шийдэл гаргаж, журмын төсөлд нэмэлт зохицуулалтыг оруулж, боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн. Ажлын хэсгийн гишүүдийн саналд үндэслэн журмын төслийг батлуулах хугацааг 6 сараар хойшлуулахаар тогтсон. | 50 | IV | БТГ |
| 3 | Арга хэмжээ 1.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | 1.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд нийт 14 төслийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 01/260 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Мөн "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд саналаа 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/617 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>2.Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд дахин санал авч байгаатай холбогдуулан төлөвлөгөөний төсөлд салбарын танилцуулга болон төслийн тайлбар үндэслэлийг 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 01/380 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн.<br>3.Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд Үндэсний хиймэл дагуул төсөл, харилцаа холбооны дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглан төрийн инновацийг хөгжүүлэх төсөл, мэдээлэл технологийн хаб байгуулах төсөл, аймгуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх төсөл, нотариатын үйл ажиллагааг үе шаттай цахимжуулах зэрэг нийт 11 төслийг тусгасан бөгөөд УИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн (35 дугаар тогтоол) чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан. | 100 | I | БТГ |
| 4 | Арга хэмжээ 1.4. Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлахтай холбоотой материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төсөлд 20 байгууллагаас саналыг авч, Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зөвшөөрөл авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | 100 | I | БТГ |
| 5 | Арга хэмжээ 1.5. Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглэх, нэвтрүүлэх журмын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | Нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн сум, багийн 2360 байршилд шуудангийн нэгдсэн кодын жагсаалтыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 6950 дугаарт бүртгүүлсэн.<br>Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглэх, нэвтрүүлэх журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | 75 | II | БТГ |
| 6 | Арга хэмжээ 1.6. Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ. | 15.0 Урсгал зардал | - | Тайлангийн тоо | 2003 онд батлагдаж, 2019 онд нэмэлт, өөрчлөлт орсон. | 1 | Шуудангийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлгэх ажлын даалгаврыг боловсруулж, уг ажлыг гүйцэтгүүлэхээр 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 03/1054 дугаартай албан бичгийг зөвлөх байгууллагуудад хүргүүлж, зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд тайланг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авсан. | 100 | I-II | БТГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Арга хэмжээ 1.7. Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батална. | - | - | Баталсан баримт бичгийн тоо | 1 | 1 | Журмын төслийг эхний байдлаар боловсруулсан. Тус яамнаас 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан "Шийдэлтэй уулзалт: Шуудангийн салбарын шинэчлэл" уулзалтын үеэр гаалийн байгууллагын төлөөлөлтэй уулзаж, уг журмын талаар санал солилцож, гаалийн мэдүүлгийн системийг хүр системтэй холбох, үүнтэй холбоотой зохицуулалтыг тус журмын төсөлд тусгах шаардлагатай гэж үзэн хойшлуулсан. | 50 | II-III | БТГ |
| 8 | Арга хэмжээ 1.8. Өргөн нэвтрүүлгийн талаар баримтлах бодлогын чиглэлийг батална. | - | - | Баталсан баримт бичгийн тоо | - | 1 | Бүгд Найрамдах Солонгос Улсын Мэдээллийн нийгмийн хөгжлийн институт (KISDI)-тэй "Монгол Улсын өргөн нэвтрүүлгийн бодлого боловсруулах" зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд Монгол Улс болон олон улсын өргөн нэвтрүүлгийн хууль, эрх зүйн орчин, бодлогын судалгаа, тайлангийн төслийг 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авсан. | 70 | I-II | БТГ |
| 9 | Арга хэмжээ 1.9. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний "2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулна. | - | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 1 | 1 | Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны Стратеги, төлөвлөгөөний төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан (2024.03.12-2024.05.28), уг ажлын хэсгийн хурлыг 03 дугаар сарын 13, 05 дугаар сарын 09, 28-ны өдөр тус тус зохион байгуулсан.<br>Стратеги төлөвлөгөөний бүрдэл хэсгүүд болох салбарын өнөөгийн байдал, стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага, мандатын шинжилгээ, орчны шинжилгээг хийж, зорилго зорилтуудыг тодорхойлсон. Ажлын хэсгийн ээлжит хурлаар гишүүдэд танилцуулан хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд санал авч, стратеги төлөвлөгөөний төслийг эцэслэн гаргасан. (Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсаны дараа уг баримт бичигтэй нийцүүлэн, дахин боловсруулалт хийх шаардлагатай.) | 100 | I-II | БТГ |
| 10 | Арга хэмжээ 1.10. Гамшигийн болон онцгой байдлын талаар урьдчилсан зарлан мэдээлэх ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргана. | - | - | Зөвлөмжийн тоо | - | 1 | Гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилсан зарлан мэдээлэх ажиллагааг сайжруулах зөвлөмжийн төсөл боловсруулсан. | 50 | III | БТГ |
| 11 | Арга хэмжээ 1.11. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 109 хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар, орон нутагт сурталчлан таниулна. | - | - | Арга хэмжээний тоо | - | 10 | Төрийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар бүрд танилцуулж, төрийн албан хаагч нарт мэдээлэл өгөх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" уулзалт, зөвлөгөөнийг Монголын хүүхдийн ордны их танхимд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр боловсролын байгууллагын 500 гаруй албан хаагч, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагч, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хууль сахиулах байгууллагын 350 орчим албан хаагч, төрийн албаны 400 орчим албан хаагчийг хамруулан тус тус зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд ЦХХХ-ны дэд сайдаар ахлуулсан баг 21 аймагт зохион байгуулсан "Цахим хөгжлийн өдөрлөг" арга хэмжээний үеэр төрийн байгууллагын албан хаагчдын болон бизнес эрхлэгч нарт тус яамнаас батлуулсан хууль тогтоомж, хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар танилцуулсан. | 100 | I-II | БТГ |
| Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.1, ЗГҮАХ-ийн 4.1.2, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3 | | | | | | | | | | |
| Зорилт 2. Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр журмын төсөл боловсруулна. | | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 3 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төсөл болон нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулсан. | 50 | I-II | ЦХБХЗГ ЦЗХ |
| 12 | Арга хэмжээ 2.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт, нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 2 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төсөл болон нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулсан. Мөн тус ажлыг 2024 онд хийхээр Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд тусгасан. | 30 | I | ЦХБХЗГ БТГ |
| 13 | Арга хэмжээ 2.2. "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг боловсруулсан. | 70 | II | ЦЗХ |
| Зорилт 3. Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо<br>Баталсан баримт бичгийн тоо Зөвлөмжийн тоо | - | 1<br>5<br>1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг батлуулсан.<br>3 баримт бичиг боловсруулсан. | 82.9 | I-III | БТГ |
| 14 | Арга хэмжээ 3.1. Мэдээллийн технологийн тухай анхдагч хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн төслийн тоо | - | 1 | Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | 100 | I | БТГ |
| 15 | Арга хэмжээ 3.2. Салбарын статистик мэдээ, мэдээллийн цахим самбар /дашбоард/-ыг бий болгох, түүнийг бүрдүүлэх, ашиглах журмыг батална. | - | - | Баталсан журмын тоо | - | 1 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын "хяналтын самбар" (dashboard)-т байрших ерөнхий мэдээлэл, байршуулах мэдээлэл, мэдээлэл хариуцагч байгууллага, мэдээлэл нийлүүлэх формат зэргийг агуулсан 95 жагсаалт болон журмын төслийг боловсруулсан. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр батлагдсан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн чиг үүрэгт холбогдуулан цугларсан мэдээлэл, мэдээллийн сан болон холбогдох мэдээллийг 3 байгууллага ирүүлээд байна. | 70 | I | СШХ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 9. Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулна. | - | - | Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний тоо | 33 | 42 | Эрүүл мэндийн салбарын төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны /HealthESB/ системийг хөгжүүлсэн. Үүнд шинээр 24 API сервисийг хөгжүүлж үндсэн ситсемд нийүүлэн, эрүүл мэндийн 7 үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн. Эрүүл мэндийн салбарт нийт 57 API сервис ажиллаж байна.<br>4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг анх бичиж буй эмнэлгээс шууд үндсэн систем "ХУР"-д нийлүүлэх API сервис (WS300167_GetChildrenBirthInfo, WS300166_GetEcareByRegnum)-ийн хөгжүүлэлтийг хийлгэсэн.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, И-Монгол академи УТҮГ-тай хамтран цахим хуудас (shinehorshoo.gov.mn)-ыг 2024 оны 05 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>Нээлттэй мэдээллийн "shilen.gov.mn" системийн 2.0 хувилбарыг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. | 100 | I-IV | ЦЗХ |
| 30 | Арга хэмжээ 9.1. Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ. | - | - | Мэдээлэл солилцох сервисийн тоо | 33 | 40 | 1.Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт ажиллаж, 8 удаагийн хурлыг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.<br>2.ЭМТХуулийн 8.4, 8.10 дахь хэсэгт заасан журмын төслийг боловсруулж, ЗГ-ын 100 дугаар тогтоол, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан.<br>3.Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, үндсэн системд 24 шинэ API сервисийг нэвтрүүлж, 346 эмнэлгийг холбосон. Хөгжүүлэлтийн 6 удаагийн туршилтыг хийж, 2024 оны 04 дүгээр сарын 03, 17-ны өдөр 4 эмнэлэг, ЭМДЕГ, ЧДХХҮГ-т очиж шалгасан.<br>4.Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн. Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулж, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл чөлөөлүүлсэн.<br>5.Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 зогсуур, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг Үндэсний дата төвөөс үзүүлж байгаа судалгаар гаргасан.<br>6.Эрүүл мэндийн 9 үйлчилгээг eMongolia системд нэвтрүүлэн бүрэн ашиглалтад нэвтрүүлсэн ба 17,437,952 мэдэгдлийг хүргэж, 729,055 хандалтыг авсан. Олон нийтэд хүргэх 7 контентыг түгээсэн.<br>7."Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг хийж, нээлттэй түгээсэн.<br>8."Эмийн жорын маягт, жор бичилт, жороор олгохтод тавих шаардлага" MNS 5376:2016-ыг шинэчлэх төсөлд цахим жор бичилттэй холбоотой саналаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар хүргүүлсэн.<br>9.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тогтоолд цахим шилжилтийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлаар харилцан мэдээлэл солилцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгтт ажиллаж, 2024 оны 09 дүгээр сарын 12, 13, 17, 18, 19-ний өдөр Номун эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, "Ариун чанар" ӨЭМТ, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, "Тэгш-Өлзий" ӨЭМТ нийт 6 эмнэлэгт ажиллан эмч, ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч, цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлсэн. | 100 | I-IV | ЦЗХ |
| 31 | Арга хэмжээ 9.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | - | - | Арга хэмжээний тоо | - | 1 | Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэд эрүүл мэндийн лавлагаа, тодорхойлолтыг цаасаар гаргуулан, харьяалах анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагад очиж Эрүүл мэндийн даатгалын цахим систем (www.health.gov.mn)-д бүртгүүлдэг, анх лавлагаа, тодорхойлолт олгож буй эмнэлгээс шууд бүртгэх боломжгүй байдал нь өрх, сумын эмнэлгийн эмчийн ачааллыг нэмэгдүүлдэг болохыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран дүүргийн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар дээр 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр очиж судалсан. Эрүүл мэндийн даатгалын (www.health.gov.mn) систем болон Халамжийн нэгдсэн систем (www.ehalamj.mn) хоорондоо шууд холбогдсон нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.9 дэх "Мэдээлэл хариуцагч хоорондоо болон мэдээлэл хариуцагчаас хүн, хуулийн этгээдтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцохдоо үндсэн системийг ашиглана." гэж заасныг зөрчиж байсныг илрүүлсэн. Улмаар холбогдох чиглэлийг 05 дугаар сарын 01-ний өдрийн 03/945 дугаартай албан бичгээр И-Монгол академи УТҮГ-т хүргүүлж, тус 4 төрлийн лавлагаа, тодорхойлолтыг анх бичиж буй эмнэлгээс шууд үндсэн систем "ХУР"-д нийлүүлэх API сервис (WS300167_GetChildrenBirthInfo, WS300166_GetEcareByRegnum)-ийн хөгжүүлэлтийг хийлгэж, Үндэсний дата төв, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 05 дугаар сарын 24-ний өдөр хүргүүлсэн.<br>Түүнчлэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт шаардлагатай мэдээллийг Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны систем"-ээр дамжуулан үндсэн систем (ХУР)-д нийлүүлэх талаар Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн хөгжлийн төвд 05 дугаар сарын 29-ний өдрийн 03/1133 дугаартай албан бичиг хүргүүлсэн. | 100 | I-IV | ЦЗХ |
| 32 | Арга хэмжээ 9.3. Хүнс хөдөө, аж ахуйн салбарын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлнэ. | - | - | Арга хэмжээний тоо | - | 1 | 1.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай" 166 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Шинэ хоршоо-Чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөний 2.7 дахь хэсэгт "Малчдад зориулсан цахим системийг хөгжүүлж, шаардагдах мэдээллийг байршуулах" зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, И-Монгол академи УТҮГ-тай хамтран цахим хуудас (www.shinehorshoo.gov.mn)-ыг 2024 оны 05 дугаар сард ашиглалтад оруулсан.<br>2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.e-mongolia.mn)-д "Малчин" цэсийг шинээр ашиглалтад оруулж, өмнө нь тусдаа байсан мал тооллогын лавлагаа, малчны тодорхойлолт, мал бүхий иргэний тодорхойлолт зэрэг үйлчилгээг авах нэг дор авах боломжтой болгосон.<br>3.Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч гишүүний лавлагаанд хуулийн этгээдийн нэр, хэлбэр, регистрийн дугаарыг нэмсэн. Ингэснээр хоршооны гишүүнчлэлийн лавлагаар Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс авах боломжийг бүрдүүлсэн. | 100 | I-IV | ЦЗХ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | Арга хэмжээ 9.4. Мэдээллийн технологид суурилсан гараа бизнес эрхлэгчдийг дэмжих ажлыг зохион байгуулна. | - | - | Үйл ажиллагааны тоо | - | 3 | 1."Хиймэл оюун ухааны бизнесийн байгууллагад хэрэглэх: АНУ-ын жишээн дээр" сэдвээр мэдээлэл технологийн гарааны компаниудын захирлуудтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр уулзалт зохион байгуулж, хиймэл оюуны чиглэлээр санал солилцсон.<br>2.Мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих хүрээнд "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай" хуулийн төслийн хэлэлцүүлгийг Төрийн ордонд 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулж, холбогдох санал, хүсэлтийг хүлээн авсан.<br>3.Технологийн салбарын ажиллах хүчний чадамжийг "Өгөгдлийн шинжилгээ", "UI/UX загварчлал", "Кибер аюулгүй байдал", "Мэдээллийн технологийн дэмжлэг", "Төслийн удирдлага", "Дижитал маркетинг" зэрэг 6 чиглэлээр "Grow with Google Mongolia" хөтөлбөрийн эхний 350 суралцагчдыг сургахад дэмжлэг үзүүлсэн. Тус хөтөлбөрт хамрагдахаар 2,292 хүсэлт ирсэн ба үүнээс 350 оролцогчийг сонгон шалгаруулж, хамруулсан.<br>4.Монгол Улсад эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор нээлттэй өгөгдлийг ашиглан бизнесийн загваруудыг боловсруулах хакатоныг Эрүүл мэндийн хөгжлийн төв, Мэдээлэл, технологийн үндэсний парк, ЖАЙКА ОУБ-тай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 02 06-ны өдөр зохион байгуулах бэлтгэл ажлын хангасан.<br>5."Шинжлэх ухаан технологийн паркуудын бүс нутгийн хөгжилд хүлээх үүрэг, үзүүлэх нөлөө" уриан дор явагдах шинжлэх ухаан, технологийн паркуудын стратегийн үүрэг, нийгэм эдийн засгийн нөлөө, жендерийн тэгш байдал, ногоон шилжилт, тогтвортой экосистемийг тодорхойлох чуулга уулзалтыг Азийн Шинжлэх Ухааны Паркийн Холбоо (ASPA)-той хамтран, 2024 оны 08 дугаар сарын 19-21-ний өдөр зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>6.БНСУ-ын технологид суурилсан гарааны компаниудын туршлага судлах, хөрөнгө оруулалт татах зорилготой "Монгол Солонгос технологийн компаниудын бизнес уулзалт"-ыг 2024.10.09-ний өдөр Мэдээлэл технологийн үндэсний паркд зохион байгуулсан. БНСУ-ын "Guruship Korea", "Honeypot Ventutres", "Misheel" хүрээлэн оролцсон. Тус уулзалтад МУ-аас нийт 7 компани оролцсон.<br>7.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.10.08-ны өдрийн А/31 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Хакатон-шинэ санаа шийдэл", "Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж" эрдэм шинжилгээний хурал, "Ability expo 2024" үйл ажиллагаанд И-Монгол, ТЦҮГ-тай хамтран оролцсон.<br>8.Финтех, хиймэл оюун ухаан, IoT, блокчэйн, хиймэл дагуул, тоглоомын салбарт үйл ажиллагаа явуулдаг Монголын 10 стартап компани Японы Токио, Саппоро хотод 2024.09.10-13-ны хооронд үйлчилгээгээ хөгжүүлэх, компани, хөрөнгө оруулагчидтай холбогдох зорилготойгоор питч танилцуулга, уулзалт зохион байгуулсан. | 100 | I-II | ЦЗХ |
| 34 | Арга хэмжээ 9.5. Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг хөгжүүлэх бодлогын даалгаврыг батална. | - | - | Батлагдсан бодлогын даалгаврын тоо | - | 1 | Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг хөгжүүлэх бодлогын даалгаврыг 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга баталсан. Төрийн байгууллагуудын цахим хуудсыг хөгжүүлж, загвар (gov.mn)-ыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд бүрэн хөгжүүлж, Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ (emongolia.mn)-тай холболт хийсэн. Тус системд нэмэлтээр egune AI чат, танилт нэвтрэлтийн ДАН систем, хүртээмжтэй байдлыг WCAG стандарт болон мэдээллийн аюулгүй байдлын бусад шалгуурыудыг нэвтрүүлсэн."И-Монгол академи" УТҮГ-ын захирлын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/105 дугаар тушаалаар Монгол УлсынЗасгийн газрын төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас gov.mn платормд нэвтрэх эрхийг үүсгэн ашиглах, нэвтрүүлэх сургалтын хөтөлбөрийг баталж, 10 дугаар сарын 17-18-ны өдөр Засгийн газрын 16 яам, нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төрийн байгууллагын цахим хуудсыг хариуцах эрх бүхий албан хаагч (байгууллагын админ)-д танхим болон цахим хэлбэрээр сургалтыг зохион байгуулсан. Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газраас 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ирүүлсэн зөвлөмжийн дагуу тус системийн бичиг баримт, гарын авлагыг бэлтгэж байна. | 100 | I | ЦЗХ |
| 35 | Арга хэмжээ 9.6. Олон Улсын төлбөр тооцооны системийг Монгол Улсад ашиглах боломжийг бүрдүүлнэ. | - | - | Монгол Улсад нэвтэрсэн олон улсын төлбөр тооцооны системийн тоо | - | 1 | ЦХХХ-ны сайд 2024 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсад (АНУ) ажлын айлчлал хийсэн бөгөөд "Apple" компанийн Засгийн газрын харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч Nick Gammon, "Visa" компанийн Засгийн газартай харилцах дэд ерөнхийлөгч Майкл Нунес болон бүтээгдэхүүн хөгжүүлэлт хариуцсан дэд ерөнхийлөгч Тодд Вэйд нартай төлбөр тооцооны системийн талаар санал солилцож, "Apple pay" олон улсын төлбөр тооцооны хэрэгслийг Монгол Улсад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар тохиролцсон. Хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр "Apple Pay" нэвтрүүлэлт Монгол Улсад хийгдсэн. | 100 | III-IV | ЦЗХ |
| ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа-2050"-ын 5.3.2, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.5, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.2, ЗГҮАХ-ийн 4.1.5, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 4.1.3.2, яамны стратеги төлөвлөгөөний 2.1.3 | | | | | | | | | | |
| | Зорилт 10. Шинжлэх ухааны байгууллага, судалгаа шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна. | - | - | Мэдээллийн сангийн тоо<br>Хэрэглэгч байгууллагын тоо | -<br>- | 1<br>2 | Мета-өгөгдлийн платформ (https://metadata.nso.mn) хөгжүүлж, 2024 оны 05 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах шийдэл боловсруулах судалгааг гүйцэтгүүлж, тайланг хүлээн авсан. | 50 | I-IV | НМДБХ |
| 36 | Арга хэмжээ 10.1. Их өгөгдлийн (big data) сан үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | - | - | Мэдээллийн сангийн тоо<br>Хэрэглэгч байгууллагын тоо | -<br>- | 1<br>2 | "Их өгөгдлийн (big data) сан"-г үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр Үндэсний статистикийн хороотой хамтран дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан, тэдгээрийн их өгөгдлийн санд нэгтгэх суурь нөхцлийн бэлэн байдлын үнэлгээ, мэдээллийн сангийн мета-өгөгдлийн судалгааны өгөгдөл, хүн ам, өрхийн бүртгэлийн сан, статистикийн бизнес регистрийн сан, мал тооллогын мэдээллийн сангийн өгөгдлийг агуулсан Мета-өгөгдлийн платформ (https://metadata.nso.mn) хөгжүүлж, 2024 оны 05 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн. Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан (https://metadata.nso.mn/)-д төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийг багц (мэдээллийн сан)-44, хүснэгт-454, үзүүлэлт-7137, ангилал, код-725, тэдгээрийг цуглуулж байгаа маягт-248 бүрдүүлсэн.<br>2.Мета-өгөгдлийн нэгдсэн сангаас хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг тодорхойлох, мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгон Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ээр дамжуулах шийдэл боловсруулах судалгаар зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлж, тайланг хүлээн авсан.<br>3.Мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох аргачлалын дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (И-Монголиа)-ээс үйлчилгээ авсан 10 мянган мөр өгөгдлийг ашиглан хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох туршилтыг И-Монгол академи УТҮГ-тай хамтран хийж гүйцэтгэсэн.<br>Их өгөгдлийн санг үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх, төрөлжсөн мэдээллийн сангаас мэдээлэл нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг хязгаарлалттай мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга хэрэгсэл бүхий модуль хөгжүүлэх, төрөлжсөн мэдээллийн сангаас Үндсэн систем (ХУР)-ээр дамжуулан их өгөгдлийн санд мэдээлэл нийлүүлэх ажлыг эхлүүлээд байна. | 50 | I-II<br>III-IV | НМДБХ |

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа-2050"-ын 5.3.3, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, ЗГҮАХ-ийн 4.1.1, 4.1.3, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2.2.1, 2.2.2, 2.3.9, МУ-ын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний 7.3, 7.4, 4.1.3.3, яамны стратеги төлөвлөгөөний 2.2.1

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 11. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | - | - | ХУР-д шинээр хөгжүүлсэн сервисийн тоо<br>Системийн хувилбарыг сайжруулсан эсэх Тийм-1, Үгүй-0<br>Албан бичиг солилцооны дундын системд | 668<br>-<br>1530 | 718<br>1<br>2500 | Хур системд 57 сервис үйлчилгээг шинээр хөгжүүлэн 810 сервис үйлчилгээ холбосон.<br>mCloud системд 54 байгууллагын үндсэн болон дэд систем бүхий нийт 313 зохиомол серверийг үүсгэж, ReHOSTING байдлаар үүлэн орчинд шилжүүлсэн.<br>Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-ийн 4.0 хувилбарыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр нэвтрүүлсэн.<br>Албан бичиг солилцооны дундын системд 321 байгууллага шинээр холбогдож, 2326 байгууллага албан бичгийг цахим хэлбэрээр солилцож байна. | 86 | I-IV | НМДБХ<br>ЦЗХ |
| 37 | Арга хэмжээ 11.1. Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-д холбогдох үйлчилгээ (сервис)-ний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | - | Шинээр нийлүүлсэн сервисийн тоо | 668 | 718 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 57 сервис үйлчилгээг шинээр хөгжүүлэн холбох ажлыг зохион байгуулж, тайлант хугацаанд 810 сервис үйлчилгээ холбогдсон.<br>Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР) ашиглан үйлчилгээ үзүүлэх 180 гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, хувийг Үндэсний дата төв УТҮГ, И-Монгол академи УТҮГ, Тагнуулын ерөнхий газарт цахим хэлбэрээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 813 сервис,Төрийн мэдээлэл солилцооны систем (www.xyp.gov.mn)-ээр дамжуулан солилцож, төрийн 148, хувийн 369 байгууллага, Танилт, нэвтрэлтийн систем (www.dan.gov.mn)-д төрийн 87 байгууллагын 167 систем, хувийн 231 байгууллагын 267 систем тус тус холбогдсон байна.<br>Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР) болон дэмжих системтэй холбоотой цахим шуудан (burtgel@mddc.gov.mn)-д ирүүлсэн 901 санал, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажилласан. | 100 | I-IV | НМДБХ |
| 38 | Арга хэмжээ 11.2. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ. | - | - | Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | - | 4 | Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Ухаалаг засаг 2" төслийн хүрээнд "Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх" ажлын даалгавар боловсруулан Дэлхийн банканд хүргүүлсэн.<br>"ХУР" мэдээлэл солилцооны системийг тархсан бүтэц шилжүүлэх төсөлд техникийн зөвлөх сонгон шалгаруулах урилгыг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр нээлттэй зарласан. Сонгон шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн баримт бичгийг үнэлэх ажил хийгдэж байна. | 30 | I-IV | НМДБХ |
| 39 | Арга хэмжээ 11.3. Мэдээлэл хариуцагч байгууллагын системийг үүлэн (mCloud) технологид шилжүүлнэ. | - | - | Шилжүүлсэн системийн тоо | - | 50 | 1.Үндэсний дата төв УТҮГ-аас 2024 онд mCloud системд 54 байгууллагын үндсэн болон дэд систем бүхий нийт 313 зохиомол серверийг үүсгэж, ReHOSTING байдлаар үүлэн орчинд шилжүүлсэн.<br>2.Мэдээлэл хариуцагч байгууллагаас шинээр үүсгэх системийг SaaS түвшинд нийцүүлэн хөгжүүлэлт хийхэд анхаарах талаар зөвлөмж, дүгнэлтэд тусгаж ажилласан.<br>3."Үндэсний дата төв" УТҮГ-ын үүлэн (mCloud) системд мэдээлэл хариуцагч байгууллагын системийг шилжүүлэх үйл явцын хэрэгжилтийг сар тутам авч, хууль тогтоомжийн биелэлтэд тусгасан. | 100 | I-IV | НМДБХ |
| 40 | Арга хэмжээ 11.4. Үндэсний программ хангамжийн их дэлгүүр "Mindgolia" системийг худалдан авах ажиллагааны цахим системтэй уялдуулна. | - | - | Үйл ажиллагааны тоо | - | 1 | Үндэсний программ хангамжийн их дэлгүүр "Mindgolia" систем ашиглан худалдан авалтын статистик мэдээллийг нэгдсэн хяналтын самбар (dashboard)-аар харах боломжийг бүрдүүлсэн. | 50 | I-IV | НМДБХ |
| 41 | Арга хэмжээ 11.5. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-Mongolia)-ийн 4.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | - | - | Нэвтрүүлсэн хувилбар | 3.0 хувилбар | 4.0 хувилбар | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем e-Mongolia 4.0 хувилбарыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр олон нийтэд танилцуулсан бөгөөд системийн аппликейшн болон веб сувгийн 4.0 хувилбарын хүрээнд дараах өөрчлөлт, шинэчлэлүүд нэмэгдсэн. Үүнд:<br>1.Үйлчилгээг ухаалгаар санал болгох буюу хэрэглэгчийн системд нэвтэрсэн өдөр, нас, хүйсийн мэдээлэлд үндэслэн хамгийн их авсан 10 үйлчилгээг санал болгодог болсон.<br>2.Хэрэглэгчийн системд нэвтэрч үйлчилгээ авдаг гол шалтгаан болсон үйлчилгээний төрлүүдийг ангилж үйлчилгээ авахад илүү хялбар болгосон.<br>3.Өөрийн авах үйлчилгээгээ дуу хоолойгоо ашиглан хайх боломжийг Чимэгэ системстэй хамтран бүрдүүлсэн.<br>4.Эрүүл мэндийн үйлчилгээг цахимжуулах ажлын хүрээнд E-Mongolia 4.0 хувилбараар эрүүл мэндийн цогц үйлчилгээг нэвтрүүлсэн.<br>5."E-mongolia chat"-ийг МонголНеттэй хамтран хөгжүүлсэн ба аппликэйшн болон веб сувгуудаар чатлах боломжтой болсон.<br>6.Ekids цэсэнд нас насны ангилалд тохирсон Хүрээлэл цэсийг МонголНеттэй хамтран хөгжүүлсэн.<br>7.Үндсэн дизайн болон бусад нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. | 100 | I -IV | НМДБХ |
| 42 | Арга хэмжээ 11.6. Төрийн үйлчилгээний операторын системийн 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | - | - | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 хувилбар | 2.0 хувилбар | Хүн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд системийн тасалдал, саатал, хэвийн үйл ажиллагааг хангах, хөгжүүлэх, сайжруулахад зорилгын хүрээнд операторын системийн UI/UX дизайныг хэрэглэгчид ойлгомжтой, хялбар, гацаалтгүй, хянах самбартай байхаар 2.0 хувилбарыг хөгжүүлж, 2024 оны 02 дугаар сард хэрэглээнд нэвтрүүлсэн.<br>Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (Оператор)-ийг хөгжүүлэх, алдаа дутагдлыг засаж сайжруулах ажлын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | 100 | I-IV | ЦЗХ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | Арга хэмжээ 11.7. Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-ийн 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ. | - | - | Нэвтрүүлсэн системийн тоо | 1.0 хувилбар | 2.0 хувилбар | 1.Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системийн 2.0 хувилбарыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлж, 04 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Тус 2.0 хувилбарт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны (GPT) технологийг сургаж, мэдээлэл хариуцагч хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллээ байршуулах, үнэн зөвийг хариуцах, өөрийн системийг шууд холбох боломжийг бүрдүүлсэн. Мөн 2023 оны бүх мэдээллийг шинэ хувилбарт хөрвүүлэн байршуулсан.<br>2.Үндсэн систем “ХУР”, тусгай зөвшөөрлийн “licence.mn” системүүдийн API сервисийг холбосон.<br>“Shilen.gov.mn” системд байршуулсан газрын дэлгэрэнгүй мэдээлэл, хэвлэлийн хурлын тоймыг 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны ажлын хэсэгт цахим хэлбэрээр, “Шил” ажиллагааны хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулахаар Ерөнхий сайдын Ажлын албанд 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт, "Шилэн индекс"-ийн үнэлгээг хянан, баталгаажуулах, холбогдох сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Мөн Shilen.gov.mn” системийн 8 төрлийн гарын авлагыг цахим хэлбэрээр байршуулж, мэдээлэл хариуцагч байгууллагуудад 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1142 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>3.“shilen.gov.mn” 2.0 системд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар мэдээлэл хариуцагч 1413 байгууллагын 1,635 албан хаагчийг бүртгэж, 1021 албан хаагчдад сургалт хийсэн.<br>4.Нээлттэй мэдээллийг 87 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 571 байгууллага тайлан ирүүлснээс 513 байгууллагын үнэлгээг хийж нийтэлсэн. Үүнд төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 90.07%, төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 93.97%, нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 72.61% гэсэн үзүүлэлттэй байна. | 100 | I-II | ЦЗХ |
| 44 | Арга хэмжээ 11.8. Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | - | Байгууллагын тоо | 1530 | 2500 | “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгийн хүрээнд төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, сургалтын агуулгад албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээний талаар тусгасан. Сургалтад төрийн 3,161 албан хаагч хамрагдсан.<br>Мөн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 23 дугаар тэмдэглэлийн 2.4-т “Төрийн байгууллагын албан бичиг солилцооны дундын систем “DocX”-ийг ашиглан цахим хэлбэрээр баримт бичиг солилцож, төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж ажиллах” гэж тус тус үүрэг болгосны дагуу 2024 онд 2326 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна. | 90 | I-IV | НМДБХ |
| ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ: "Алсын хараа-2050"-ын 5.2, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.21, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.2, яамны стратеги төлөвлөгөөний 2.3.1 | | | | | | | | | | |
| Зорилт 12. Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, нээлттэй өгөгдөл, мэдээллийг уялдуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | | - | - | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | - | 45 | Төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийн багц (мэдээллийн сан)-45, хүснэгт-453, үзүүлэлт-7137, ангилал, код-725, тэдгээрийг цуглуулж буй маягт-248 бүхий өгөгдлийг бүрдүүлээд байна. | 100 | III-IV | НМДБХ |
| 45 | Арга хэмжээ 12.1. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө. | - | - | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | - | 45 | 1.Мета-өгөгдлийн цахим платформ бий болгох ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороотой хамтран мэдээллийн сангийн мета-өгөгдөл цуглуулах цахим асуулгын хуудсыг боловсруулан https://ee.kobotoolbox.org/x/NvY5ulj5 хэрэгслээр тоон болон чанарын судалгаа (тоон судалгаанд 43, чанарын судалгаанд 11 байгууллага) авсан.<br>2.Мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сангийн мета-өгөгдлийн судалгаанд холбогдох мэдээллийг ирүүлээгүй, нөхөн ирүүлэх шаардлагатай мэдээлэл хариуцагч 15 байгууллагыг судалгаанд бүрэн хамруулах албан бичиг (2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/402, 01/403, 01/404, 01/405, 01/407, 01/408, 409, 01/410 дугаар)-ийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн.<br>3.Үндэсний статистикийн хороотой хамтран судалгааны үр дүн бүхий мэдээллийн сангийн өгөгдлийг "Мета-өгөгдлийн платформ"-ыг бий болгож, 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хэрэглээнд нэвтрүүлсэн. Тус платформд төрийн байгууллагуудын үүсгэсэн өгөгдлийн багц (мэдээллийн сан)-45, хүснэгт-453, үзүүлэлт-7137, ангилал, код-725, тэдгээрийг цуглуулж буй маягт-248 бүхий өгөгдлийг бүрдүүлээд байна. Ингэснээр суурь болон төрөлжсөн 45 мэдээллийн сангийн мета өгөгдлийг журамд заасан төрөлжсөн бүртгэлийн санд нэгтгэх нөхцөлийг бүрдүүлсэн.<br>4.“Төрөлжсөн бүртгэлийн сангийн бүртгэл, мэдээллийн систем хөгжүүлэх” ЦХХХЯ/20240103036 дугаартай тендер шалгаруулалт амжилтгүй болсноор цахимаар бүртгэл хөтлөх нөхцөл бүрдээгүй, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах боломжгүй болсон.<br>5.Мэдээлэл хариуцагчаас ирүүлсэн системүүдэд зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлтийг Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 164 дүгээр тогтоолоор баталсан "Төрөлжсөн бүртгэлийн жагсаалт"-д багтсан 152 төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн шийдвэрлэж ажилласан. | 100 | III-IV | НМДБХ |
| ЗГҮАХ 3.4.6.4, 4.1.5, 4.1.6, ЦХХХЯ-ны стратеги төлөвлөгөөний 3.1, 3.2, 3.3, Харилцаа холбооны чиглэлийн хууль, тогтоомж, хөгжлийн бодлого, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг зохион байгуулах | | | | | | | | | | |
| Зорилт 13. Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг хангана. | | 7.0 Урсгал зардал | - | Интернэт хаягжилтын 6 дахь хувилбар шилжсэн төрийн байгууллагын тоо<br>Гамшгийн үеийн дадлага сургуулилтын тоо | -<br>1 | 24<br>1 | Төрийн цахим хуудасны хостингийн системд байрших 1,327 төрийн байгууллагын цахим хуудсыг IPv6 хаягт бүрэн шилжүүлсэн.<br>Дадлага, сургуулилт-1 | 100 | II-IV | ХХБХЗГ |
| 112 | Арга хэмжээ 35.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төрийн болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг шинэчлэн батална. | - | - | Батлагдсан журмын тоо | 1 | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/38 дугаар тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг баталсан. Харьяа, салбарын байгууллагуудад 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 03/814 дугаартай албан бичгээр тушаалыг хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар харьяа болон төрийн өмчит газруудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, ажлын хэсгийг байгуулж, хяналт, шалгалтын ажлыг эхлүүлээд байна. | 100 | I | ХШУДАГ |
| 113 | Арга хэмжээ 35.3. Байгууллагад ирсэн хөндлөнгийн хяналтын зөвлөмжийн гүйцэтгэл, хэрэгжилтийг хянаж, зөвлөмж гаргана. | - | - | Гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлсэн албан бичгийн тоо | - | 1 | Үндэсний аудитын газраас "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан"-д хийсэн аудит, Улсын хөгжлийн 2023 оны жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр баталсан. Үндэсний аудитын газарт 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 01/786, 01/787 дугаартай албан бичгээр уг төлөвлөгөөг хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах талаар харьяа, салбар байгууллагуудад 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1119 дугаартай албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. "Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 07 дугаар сарын 04-ний 03/1389 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Үндэсний аудитын газраас санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/234 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | 100 | I-IV | ХШУДАГ |
| | Зорилт 36. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавина. | - | - | Дотоод аудит хийсэн эсэх<br>Тийм-1, Үгүй-0<br>Баримт бичгийн тоо | 1<br>2 | 1<br>2 | Дотоод аудитын төлөвлөгөөг баталсан.<br>Дотоод аудит хийсэн тоо-2<br>Зөвлөмжийн хэрэгжилт-1 | 85 | I-IV | ХШУДАГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | Арга хэмжээ 36.1. Дотоод аудитын 2024 оны дунд хугацааны төлөвлөгөө баталж, Сайдын эрхлэх асуудлын хүрээний төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад эрсдэлд суурилсан дотоод аудит хийж, зөвлөмж өгнө. | - | - | Батлагдсан дотоод аудитын төлөвлөгөө Дотоод аудит хийсэн тоо | 1 | 1 | Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны дунд хугацааны төлөвлөгөөг Дотоод аудитын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дотоод аудитын хороог ЦХИХХ-ны сайдын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Дотоод аудитын хорооны 01 дүгээр тогтоолоор батлагдсан нийт 6 ажлаас Бүх нийтийн үүргийн санд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, Үндэсний аудитын байгууллагаас ирсэн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ, төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг 3 ажлыг бүрэн хийж, удирдлагад танилцуулсан. Сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны тогтоолын дагуу сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэг Үндэсний дата төв УТҮГ-т хяналт шалгалт хийж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 03/1173 дугаартай албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.<br>Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/56 дугаар тушаалаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг баталж, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын 2023, 2024 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмж, дүгнэлтийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 03/1356 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 70 | I-IV | ХШҮДАГ |
| 115 | Арга хэмжээ 36.2. Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан, агентлаг, харьяа салбар байгууллагууд, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас хийсэн аудитын зөвлөмжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьсан баримтыг Үндэсний аудитын газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг Үндэсний аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 27-ны 01/1120 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Харьяа, салбар 8 байгууллагын удирдлагуудад холбогдох төлөвлөгөөг хүргүүлж, цаашид анхаарч ажиллах чиглэл өгсөн.<br>2023 оны санхүүгийн аудитын тайлангаар Үндэсний аудитын газрын зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгаа салбар, харьяа байгууллагуудын алдаа зөрчлийг хэрхэн арилгасан талаарх тайлбарыг нотлох баримтын хамт Үндэсний аудитын газрын цахим санд оруулж, Үндэсний аудитын газарт зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 01/235 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100 | III | ХШҮДАГ |
| Зорилт 37. Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | | - | - | Батлагдсан баримт бичгийн тоо<br>Хүргүүлсэн баримт бичгийн тоо | -<br>- | 6<br>1 | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах обьектын жагсаалтыг баталсан.<br>Шинэчлэн батлагдсан хяналтын хуудас-4<br>Эрсдэлийн ангиллын үнэлгээ хийсэн объектын тоо-1151 | 100 | I-IV | СХГ |
| 116 | Арга хэмжээ 37.1. Салбарын хяналт шалгалтад хамаарах объектын жагсаалтыг батална. | - | - | Батлагдсан баримт бичгийн тоо | - | 1 | Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/08 дугаар тушаалаар Мэдээлэл, харилцаа холбооны салбарын 2024 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах обьектын жагсаалтыг баталсан. | 100 | I | СХГ |
| 117 | Арга хэмжээ 37.2. Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хяналтын хуудсыг батална. | - | - | Шинэчлэн батлагдсан баримт бичгийн тоо | 4 | 5 | Салбарын хяналтын газрын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх хяналтын хуудсыг шинэчлэх ажлын хэсэг байгуулж, №09.01 Мэдээлэл, харилцаа холбооны шугам сүлжээг шалгах хяналтын хуудас, №09.02. Барилга байгууламж, харилцаа холбооны шугам сүлжээний угсралтын ажлыг шалгах хяналтын хуудас, №09.03. Радио долгион ашиглагч этгээдийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, № 09.04 Шуудангаар үйлчлэгч этгээдийг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/153 дугаар тушаалаар баталсан. | 100 | I | СХГ |
| 118 | Арга хэмжээ 37.3. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийн эрсдэлийг үнэлж, 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | - | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | - | 1 | Салбарын хяналтын 15 улсын /ахлах/ байцаагчид нийт 1151 объектод эрсдэлийн ангиллын үнэлгээ хийсэн. 2025 оны төлөвлөгөөт шалгалт хийх их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 171 объектын жагсаалтыг Засгийн газрын Хяналт, үнэлгээний үндэсний хороонд Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/695 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 62 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан. | 100 | IV | СХГ |
| Зорилт 38. Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг ухаалгаар удирдана. | | - | - | Зөвлөмж, мэдээллийн тоо | - | 3 | Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналтын талаар болон шалгалтын статистик мэдээллийг гаргаж, улсын байцаагч нарт танилцуулж, зөвлөгөө зөвлөмж өгсөн | 100 | I-IV | СХГ |
| 119 | Арга хэмжээ 38.1. Салбарын эрсдэлийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагчдад хүргүүлнэ. | - | - | Зөвлөмжийн тоо | - | 1 | 2024 оны эрсдэлийн ангиллын үнэлгээг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс хийгдэж эхэлсэн. Аймаг, нийслэлийн Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарт Шилэн хяналтын цахим системд "Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх", "Эрсдэлийг бууруулах арга авч ажиллах" сэдвээр 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр цахим сургалт хийж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан. | 100 | IV | СХГ |
| 120 | Арга хэмжээ 38.2. Салбарын эрсдэлийн төлөв байдал, холбогдох статистик мэдээллийг нэгтгэн гаргана. | - | - | Мэдээллийн тоо | - | 2 | Мэдээлэл, харилцаа холбооны хяналтаар 2024 оны хийгдсэн төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт хууль сахин мөрдөлтийн хувь, эрсдэл үүсэх магадлалын хувь, зөрчил арилгуулалтын хувь, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь нийт 4 төрлийн статистик мэдээллийг гаргаж, улсын байцаагч нарт танилцуулж, зөвлөгөө зөвлөмж өгч ажиллалаа. | 100 | II, IV | СХГ |
| Зорилт 39. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ. | | - | - | Хууль сахин мөрдөлтийн хувь<br>Эрсдэл үүсэх магадлалын хувь<br>Зөрчил арилгуулалтын хувь<br>Гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн хувь | 75.68<br>30.2<br>74<br>71 | 78<br>28.3<br>79<br>98 | 79<br>28<br>80<br>98 | 92.5 | I-IV | СХГ |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | Арга хэмжээ 39.1. Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээг хийн их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 153 объектуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийнэ. | - | - | Хууль сахин мөрдөлтийн хувь<br>Эрсдэл үүсэх магадлалын бууралтын хувь | 75.68<br>30.2 | 78<br>28.3 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны А/08 дугаартай хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн батлсан 09-00/02 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 153 объект төлөвснөөс 153 объектод төлөвлөгөөт шалгалт хийж төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай байна. Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн 749 заалттай 135 албан шаардлага, 18 заалттай 5 дүгнэлт, 51 заалттай 27 зөвлөмж хүргүүлж, 6 аж ахуйн нэгж 2 иргэнд нийт 1,880,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ, 3,500,000 төгрөгийн нөхөн төлбөр ногдуулах арга хэмжээ авч хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Албан шаардлага-88.1 хувь,<br>Дүгнэлт- 98 хувь,<br>Зөвлөмж- 100 хувь,<br>Нөхөн төлбөр- 100 хувь,<br>Торгууль- 100 хувийн хэрэгжилттэй байна. | 100 | I-IV | СХГ |
| 122 | Арга хэмжээ 39.2. Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | - | - | Зөрчил арилгуулалтын хувь | 74 | 80 | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн дагуу 25 барилга, байгууламжийн хүлээн авах комиссын ажлын хэсэг, бүрэлдэхүүнд орж ажиллан харилцаа холбооны чиглэлээр 48 үүрэг даалгавар өгч, хэрэгжилт 85%-тай байна. | 85 | I-IV | СХГ |
| 123 | Арга хэмжээ 39.3. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийнэ. | - | - | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь | 94.7 | 100 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор батлсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Салбарын улсын ерөнхий байцаагчийн батлсан 09-00/01, 02-00/14, 09-00/04, 09-00/03, 19-00/05, 09-00/06, 19-00/07 удирдамжийн хүрээнд нийт 50 аж ахуйн нэгж, 5 иргэнээс өргөдөл гомдол ирүүлж, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хянал шалгалт хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөт бус шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах 66 заалттай 14 албан шаардлага, 2 аж ахуйн нэгжид 1000 нэгжээр, 2 иргэнийг 50 нэгж, 30 нэгжээр тус тус торгуулийн арга хэмжээ авч ажилласан.<br>Албан шаардлага-98 хувь, Торгууль- 100 хувийн хэрэгжилттэй байна.<br>1."Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-иас ирүүлсэн албан бичгийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн батлсан 09-00/05 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн хүрээнд Сноу филдс ХХК-ийн СХД-ийн 20 хороонд баригдаж буй үйлдвэрийн барилын суурьнд харилцаа холбооны шугам сүлжээ орсонтой холбоотой хяналт шалгалтыг хийж, харилцаа холбооны шугам сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангах, шинээр хийх худаг сувагчлалын угсралтын ажлыг техникийн нөхцөл, зураг төслийн дагуу стандарт, норм дүрмийн шаардлагад нийцүүлэн хийж гүйцэтгэх талаар Сноу филдс ХХК-д 09-00-02/001/01 дугаартай 2 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн.<br>2.Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2024 оны 10 сарын 14-ний өдрийн 03/834 дугаартай албан бичгийн дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлсан 09-00/14 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дагуу Монгол зам групп ХХК-д ажилласан. 2025 онд ажил эхлэхэд Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн шилэн кабелийн трасс гүүрийн байгууламж болон замын 2 талаар шудуу ухахад замын трасст олон газраар давцаж байгаа тул зураг дээр ажиллаж шийдвэр боловсруулах. 2023, 2024 онуудад тасалсан шилэн кабелийн хохиролыг бүрэн барагдуулж ажилласан.<br>3. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний 2024 оны 07 сарын 29-ний өдрийн 07/652 дугаартай албан бичгийн дагуу Эрчим хүчний яамны "Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд Рутан ХХК-ий гүйцэтгэж байгаа дулааны 2А магистраль, ДХ-165 цэгээс, ДХ-221 цэг хүртэлх 2Ф350 мм-ийн голчтой шугамыг 2Ф500 мм-ийн голчтой болгож шугам өргөтгөх угсралтын ажлыг хийх явцад холбооны сувагчлал эвдэсн, дахин ашиглах боломжгүй болсон асуудалд Харилцаа холбооны тухай хууль, Барилгын тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, норм, стандартын мөрдөлтийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах 2024.08.21-ний өдрийн 09-00-03/002/05 дугаартай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хохирлыг барагдуулж ажилласан.<br>4. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний 2024 оны 08 сарын 28-ний өдрийн 07/733 дугаартай албан бичгээр ирүүлсэн Баянгол дүүргийн 3 дугаар хороо 22, 23, 24, 37-р байрнуудын суурин дээр үйлчилгээтэй орон сууцны барилгын ерөнхий гүйцэтгэгч "Орчлон Констракшн" ХХК нь С блокийн барилгын суурийн ажил гүйцэтгэх явцдаа харилцаа холбооны худаг сувагчлалын байгууламжийг эвдэж гэмтээсэн асуудалд 09-00/04 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулах 09-00-02/002/06 дугаартай улсын байцаагчийн 3 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулж ажилласан. | 100 | I-IV | СХГ |
| 124 | Арга хэмжээ 39.4. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаар хууль, тогтоомжийн хүрээнд явуулах, Улсын байцаагчийн шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг шалгана. | - | - | Зөрчил арилгуулалтын хувь | 71 | 100 | 1.Нийслэлийн прокурорын газраас ирүүлсэн 1/260 дугаар албан бичгийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны нэгдсэн судалгаар гаргаж, niislelprozurchil@gmail.com цахим шуудангаар хүргүүлсэн.<br>2.Харилцаа холбооны зохицуулах хорооноос 08/1584 дугаартай албан бичгээр Супервижн медиа групп ХХК-ийн SBN телевиз нь эд мөнгөний хонжворт сугалаатай холбоотой нэвтрүүлэг нэвтрүүлсэн нь Харилцаа холбооны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.13 дахь заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 51 дүгээр тогтоолоор батлсан "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам"-ын 3 дугаар зүйлийн 3.21 дэх заалтыг зөрчсөн тул Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1дэх хэсгийн 1.1 дэх заалтын дагуу Зөрчлийн хэрэг үүсгэн 500 нэгжээр торгох арга хэмжээ авсан.<br>3.Нийслэлийн прокурорын газраас 2023, 2024 онд Мэдээлэл, харилцаа холбооны салбарын улсын байцаагчдын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан хэргийн материалд нэгдсэн үзлэг, шалгалт хийгдэж байгаатай холбогдуулан 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. | 100 | I-IV | СХГ |

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025 оны 01 сарын 15-ны өдөр Улаанбаатар хот

## Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 124 арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээний хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

## Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 124 арга хэмжээний биелэлтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил, үүргийн дагуу тайлагнасан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарсан болно. Үүнд:

1. Бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн гүйцэтгэлтэй — 89 арга хэмжээ.
2. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй — 10 арга хэмжээ.
3. Дээд шатны байгууллагад өргөн барьсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй — 14 арга хэмжээ.
4. Боловсруулалтын шатанд байгаа буюу 50%-ийн гүйцэтгэлтэй — 6 арга хэмжээ.
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30%-ийн гүйцэтгэлтэй — 5 арга хэмжээ.
6. Үр дүнгүй буюу 0%-ийн гүйцэтгэлтэй — 0 арга хэмжээ.

Дээрх арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж түвшнийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолд заасан аргачлалын дагуу тооцож, арифметик дундажаар үнэлэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 90.56 хувьтай буюу 2024 онд тавьсан зорилт арга хэмжээ хангалттай биелэгдсэн гэж үзэхээр байна.

## Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

| № | Зорилт | Арга хэмжээ | Гүйцэтгэлийн үнэлгээ | | | | | Дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% | 90% | 70% | 50% | 30% | |
| 1 | Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана. | 11 | 5 | 1 | 2 | 3 | - | 80 |
| 2 | Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр журмын төсөл боловсруулна. | 2 | - | - | 1 | - | 1 | 50 |
| 3 | Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 5 | 1 | 1 | 3 | - | - | 80 |
| 4 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийнэ. | 2 | 1 | - | 1 | - | - | 85 |
| 5 | Салбарын статистик мэдээ, мэдээллийг боловсронгуй болгох, судалгаа, шинжилгээ хийнэ. | 1 | 1 | - | - | - | - | 100 |
| 6 | Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангана. | 2 | 2 | - | - | - | - | 100 |
| 7 | Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг сайжруулах үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангана. | 3 | 2 | - | 1 | - | - | 90 |
| 8 | Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний бодлого, журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулна. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 9 | Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулна. | 6 | 6 | - | - | - | - | 100 |
| 10 | Шинжлэх ухааны байгууллага, судалгаа шинжилгээний төв, лабораториудын үйл ажиллагааг уялдуулах, судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд бий болсон шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулна. | 1 | - | - | - | 1 | - | 50 |
| 11 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 8 | 5 | 1 | - | 1 | 1 | 83.8 |
| 12 | Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, нээлттэй өгөгдөл, мэдээллийг уялдуулах, хөгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 1 | 1 | - | - | - | - | 100 |
| 13 | Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг хангана. | 2 | 2 | - | - | - | - | 100 |
| 14 | Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийг өргөтгөх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хяналт тавина. | 2 | 1 | 1 | - | - | - | 95 |
| 15 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 3 | 2 | - | - | 1 | - | 83.3 |
| 16 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хүлээн авна. | 2 | - | - | - | - | 2 | 30 |
| 17 | Үндэсний радио давтамжийн нөөцийг үр ашигтай, зүй зохистой ашиглах, хуваарилах ажлыг төлөвлөж, хэрэгжилтийг хангана. | 1 | - | 1 | - | - | - | 90 |
| 18 | Хил залгаа улстай радио долгионы асуудлыг зохицуулна. | 2 | 1 | 1 | - | - | - | 95 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Сансрын болон дэвшилтэт технологийг нутагшуулах, газар сансар хосолсон өргөн зурвасын сүлжээг бий болгох, хэрэглээг нэвтрүүлэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлнэ. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 20 | Сансрын технологийг сурталчлах, олон нийтэд танилцуулах чиглэлээр олон нийтийн байгууллагатай хамтран ажиллана. | 1 | 1 | - | - | - | - | 100 |
| 21 | Шуудан, цахим худалдаа, логистикийн салбарт гарч байгаа шинэ техник, технологийг нэвтрүүлэх, шуудангийн үндсэн сүлжээг төрийн дэмжлэгтэйгээр хувийн хэвшилд тулгуурлан өргөтгөн хөгжүүлэх, хэрэгжүүлэх, шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулах, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2 | 1 | - | 1 | - | - | 85 |
| 22 | Радио өргөн нэвтрүүлгийн системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулна. | 1 | - | - | 1 | - | - | 70 |
| 23 | Кибер аюулгүй байдал болон хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 1 | - | - | - | - | 1 | 30 |
| 24 | Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулна. | 2 | 2 | - | - | - | - | 100 |
| 25 | Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлнэ. | 1 | 1 | - | - | - | - | 100 |
| 26 | Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, энэ чиглэлийн үйл ажиллагаатай төвүүдийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 27 | Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх, журам, шаардлага боловсруулна. | 3 | 2 | - | 1 | - | - | 90 |
| 28 | Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангана | 12 | 8 | 2 | 2 | - | - | 93.3 |
| 29 | Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын бодлого, эрх зүйн орчныг боловсронгуй болгохтой холбоотой хууль эрх зүйн туслалцаа үзүүлнэ. | 2 | 1 | 1 | - | - | - | 95 |
| 30 | Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 5 | 5 | - | - | - | - | 100 |
| 31 | Салбарын санхүү, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтийн нэгдсэн зохицуулалт хийх, хэрэгжүүлнэ. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 32 | Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 33 | Төрийн сангийн тооцоо, яамны албан хаагчдын цалин, тэтгэмж, хөрөнгийн хөдөлгөөний бүртгэл хийх, хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлнэ | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 34 | Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, даргын зөвлөлийн хурлаар оруулах, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнана. | 8 | 8 | - | - | - | - | 100 |
| 35 | Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргана. | 3 | 3 | - | - | - | - | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавина. | 2 | 1 | - | 1 | - | - | 85 |
| 37 | Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | 3 | 3 | - | - | - | - | 100 |
| 38 | Мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг ухаалгаар удирдана. | 2 | 2 | - | - | - | - | 100 |
| 39 | Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ. | 4 | 3 | 1 | - | - | - | 97.5 |
| | **Нийт** | **124** | **89** | **10** | **14** | **6** | **5** | |

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд бүрэн хэрэгжсэн, тодорхой шийдвэрүүд гар ч үр дүн гарч байгаа, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ нийт арга хэмжээний 79.8 хувийг эзэлж байна. Тухайлбал Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах зорилтын хүрээнд Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох баримт бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1182 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдуулан 2024 оны 07 дугаар сарын 19-ний ХЭГ/1298 дугаар албан бичгээр хэлэлцүүлэх тогтоолын төсөлд дахин санал авах хариу ирүүлсний дагуу 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/128 дугаартай албан бичгээр Засгийн газрын гишүүдээс тогтоолын төсөлд санал авч, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар "Нээлттэй өгөгдлийн жагсаалт"-д нэмэлт, өөрчлөлт оруулах нийтэд ил болгох төрийн 691 нээлттэй өгөгдлийн жагсаалтыг танилцуулж, шинэчлэн батлуулсан.

Нийгэм, эдийн засгийн салбарын хөгжлийг мэдээллийн технологиор дэмжих, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, хэрэглээг бий болгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зохицуулах зорилтын хангахаар Эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээ авсан. Үүнд:

1.Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт ажиллаж, 8 удаагийн хурлыг зохион байгуулж, үр дүнг Засгийн газрын 2024.03.26, 2024.07.24-ний өдрийн хуралдаанд танилцуулсан.

2.Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах журам, ЭМС, ЦХХХС-ын А/138, А/37 дугаар хамтарсан тушаалаар Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журмыг тус тус батлуулсан.

3.Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээллийн санг үүсгэж, мэдээлэл солилцооны ерөнхий схем /HealthESB/, сервисийн гарын авлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулж, үндсэн системд 24 шинэ API сервисийг нэвтрүүлж, 346 эмнэлгийг холбосон. Хөгжүүлэлтийн 6 удаагийн туршилтыг хийж, 2024 оны 04 дүгээр сарын 03, 17-ны өдөр 4 эмнэлэг, ЭМДЕГ, ЧДХХҮГ-т очиж шалгасан.

4.Иргэнээс зөвшөөрөл авах нөхцөлийг SMS (OTP), Хурууны хээ, Push notification, G-Sign хэлбэрээр бүрдүүлсэн.

Эмнэлгийн систем хөгжүүлэгч 8 компанитай гэрээ байгуулж, VPN, API-г тохируулж, ХУР, Мэдэгдлийн системийн төлбөрийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл чөлөөлүүлсэн.

5.Эрүүл мэндийн 109 байгууллагын 111 зогсуур, 67 VPS, 153 mail, 137 website, 293 domain-ны үйлчилгээг Үндэсний дата төвөөс үзүүлж байгаа судалгааг гаргасан.

6.Эрүүл мэндийн 9 үйлчилгээг eMongolia системд нэвтрүүлэн бүрэн ашиглалтад нэвтрүүлсэн ба 17,437,952 мэдэгдлийг хүргэж, 729,055 хандалтыг авсан. Олон нийтэд хүргэх 7 контентыг түгээсэн.

7."Цахим эрүүл мэндийн нөхцөл байдлын үнэлгээ"-ний судалгааг хийж, нээлттэй түгээсэн.

8.“Эмийн жорын маягт, жор бичилт, жороор олголтод тавих шаардлага" MNS 5376:2016-ыг шинэчлэх төсөлд цахим жор бичилттэй холбоотой саналаа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

9.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргасан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй тогтоолд цахим шилжилтийн үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлаар харилцан мэдээлэл солилцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгтт ажиллаж, 2024 оны 09 дүгээр сарын 12, 13, 17, 18, 19-ний өдөр Номун эмнэлэг, Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв, “Ариун чанар” ӨЭМТ, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, “Тэгш-Өлзий” ӨЭМТ нийт 6 эмнэлэгт ажиллан эмч, ажилтнуудын санал хүсэлтийг хүлээн авч, цаашид авах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулж, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг цахимжуулах зорилтын дагуу мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг амжилтай хэрэгжүүлсэн. Үүнд:

1.Нээлттэй мэдээллийн “shilen.gov.mn” системийн 2.0 хувилбарыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хэрэглээнд нэвтрүүлж, 04 дүгээр сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Тус 2.0 хувилбарт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээллийн санд хиймэл оюуны (GPT) технологийг сургаж, мэдээлэл хариуцагч хуульд байнга ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллээ байршуулах, үнэн зөвийг хариуцах, өөрийн системийг шууд холбох боломжийг бүрдүүлсэн. Мөн 2023 оны бүх мэдээллийг шинэ хувилбарт хөрвүүлэн байршуулсан.

2.Үндсэн систем “ХУР”, тусгай зөвшөөрлийн “licence.mn” системүүдийн API сервисийг холбосон.

“Shilen.gov.mn” системд байршуулсан газрын дэлгэрэнгүй мэдээлэл, хэвлэлийн хурлын тоймыг 03 дугаар сарын 04-ний өдөр Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны ажлын хэсэгт цахим хэлбэрээр, “Шил” ажиллагааны хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулахаар Ерөнхий сайдын Ажлын албанд 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврын хүрээнд Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт, "Шилэн индекс"-ийн үнэлгээг хянан, баталгаажуулах, холбогдох сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж байна. Мөн Shilen.gov.mn” системийн 8 төрлийн гарын авлагыг цахим хэлбэрээр байршуулж, мэдээлэл хариуцагч байгууллагуудад 05 дугаар сарын 31-ний өдрийн 01/1142 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.

3.“shilen.gov.mn” 2.0 системд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар мэдээлэл хариуцагч 1413 байгууллагын 1,635 албан хаагчийг бүртгэж, 1021 албан хаагчдад сургалт хийсэн.

4.Нээлттэй мэдээллийг 87 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж, 2024 оны жилийн эцсийн байдлаар 571 байгууллага тайлан ирүүлснээс 513 байгууллагын үнэлгээг хийж нийтэлсэн. Үүнд төрийн захиргааны төв байгууллагын дундаж үзүүлэлт 90.07%, төрийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 93.97%, нутгийн захиргааны байгууллагуудын дундаж үзүүлэлт 72.61% гэсэн үзүүлэлттэй байна.

Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөөний төсөлд үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчил үүссэн үед тусгайлсан чиг үүргийн байгууллагуудын эрх, үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг нарийвчлан тусгасан. Олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын төлөөллөөс ирүүлсэн саналыг төлөвлөгөөний төсөлд тусгасан. Энэхүү төлөвлөгөө нь төрийн нууцад хамаарах тул хэлэлцүүлэгт оролцсон албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулсан болно.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Тагнуулын ерөнхий газар, ЦЕГ-ын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв болон Нийтийн төвийн төлөөлөл оролцсон уулзалтыг 2024 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулж, эдгээр байгууллагуудтай зөвшилцөлд хүрсний үндсэн дээр төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулсан. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 13.1.4-т заасны дагуу тагнуулын байгууллагаас Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө болон Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан.

Төрийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар бүрд танилцуулж, төрийн албан хаагч нарт мэдээлэл өгөх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор "Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ" уулзалт, зөвлөгөөнийг Монголын хүүхдийн ордны их танхимд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр боловсролын байгууллагын 500 гаруй албан хаагч, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагч, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хууль сахиулах байгуулагын 350 орчим албан хаагч, төрийн албаны 400 орчим албан хаагчийг хамруулан тус тус зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд ЦХХХ-ны дэд сайдаар ахлуулсан баг 21 аймагт зохион байгуулсан "Цахим хөгжлийн өдөрлөг" арга хэмжээний үеэр төрийн байгууллагын албан хаагчдын болон бизнес эрхлэгч нарт тус яамнаас батлуулсан хууль тогтоомж, хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээний талаар танилцуулга хийж байгаа нь Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 109 хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар, орон нутагт сурталчлах ажлыг яам нь үр дүнтэй зохион байгуулсан гэж дүгнэж байна.

Түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт буруу буюу ерөнхий, үр дүнд хүрэхээр төлөвлөөгүй, хэрэгжих боломжгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй зэргээс шалтгаалан хангалтгүй буюу 30 хувиар үнэлэгдэж байгаа дарах арга хэмжээнүүд нийт 5 арга хэмжээ байна. Үүнд:

1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт, нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх
2. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх
3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх харилцаа холбооны сүлжээ өргөтгөх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих. ашиглалтад хүлээн авах. /Улсын хэмжээнд/.
4. Хүүхдэд ээлтэй "Итгэлтэй утас" төслийн гүйцэтгэлийг хянах, ашиглалтад хүлээж авах.
5. Кибер аюулгүй байдлын чиглэлээр дагаж мөрдөж байгаа стандартыг

үнэлж зөвлөмж гаргах, олон улсад дагаж мөрддөг стандартуудыг судалах.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийт 124 арга хэмжээний зорилтын хүрээнд тухайлан нэгж тус бүрээр:

| Д/Д | Нэгж | Төлөвлөсөн арга хэмжээ | Үнэлгээний хувь | | | | | Дундаж арга хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 | |
| 1 | Бодлого төлөвлөлтийн газар | 20 | 9 | 2 | 5 | 3 | 1 | 80.5 |
| 2 | Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар | 12 | 11 | - | 1 | - | - | 97.5 |
| 3 | Цахим засаглалын хэлтэс | 10 | 9 | - | 1 | - | - | 97 |
| 4 | Төрийн захиргааны удирдлагын газар | 10 | 7 | 1 | 2 | - | - | 93 |
| 5 | Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтэс | 10 | 6 | 1 | - | 2 | 1 | 82 |
| 6 | Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | 9 | 5 | 1 | - | 1 | 2 | 77.8 |
| 7 | Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс | 9 | 9 | - | - | - | - | 100 |
| 8 | Салбарын хяналтын газар | 9 | 8 | 1 | - | - | - | 98.9 |
| 9 | Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохцуулах газр | 9 | 8 | - | 1 | - | - | 96.7 |
| 10 | Сансарын холбооны хэлтэс | 7 | 5 | 2 | - | - | - | 97.1 |
| 11 | Хуулийн хэлтэс | 5 | 3 | 2 | - | - | - | 96 |
| 12 | Гадаад хамтын ажиллагааны хэлтэс | 5 | 5 | - | - | - | - | 100 |
| 13 | Шуудан, өргөн нэвтрүүлгийн хэлтэс | 3 | 1 | - | 2 | - | - | 80 |
| 14 | Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар | 3 | 2 | - | - | - | 1 | 76.7 |
| 15 | Судалгаа шинжилгээний хэлтэс | 3 | 1 | - | 2 | - | - | 80 |

Дээрх 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлагнасан 124 арга хэмжээнээс биелэлт 50 хувьтай үнэлэгдсэн нийт 6 арга хэмжээ байна. Үүнд:

1. Интернэтийн дундын холболтын журам батлах
2. Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах
3. Гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилсан зарлан мэдээлэх ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах
4. Их өгөгдлийн (big data) сан үүсгэж, хэрэглээнд нэвтрүүлэх
5. Үндэсний программ хангамжийн их дэлгүүр “Mindgolia” системийг худалдан авах ажиллагааны цахим системтэй уялдуулах
6. Хүүхдэд ээлтэй "Итгэлтэй утас" төслийг орон даяар хэрэгжүүлэх ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах.

## Дөрөв. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /зөвлөмж/

Хэрэгжилт хангалтгүй ажлуудыг 2025 онд эрчимжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Яамны бодлого төлөвлөлтийн болон бодлогын хэрэгжилтийн зохицуулах газруудад:

1. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, тооцоо судалгаанд үндэслэсэн баримтад тулгуурлан гаргаж хэвших;
2. Үр дүнд суурилсан бодит нотолгоотой тайлан бичиж ирүүлэх;
3. Яамны төрийн захиргааны тайлан мэдээг нэгтгэж буй албан хаагчийн баримт нотолгоотой, товч ойлгомжтой биелэлтийг шуурхай хүргүүлж хэвших;
4. 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг тайлагнаж хэвших;
5. Яамны төлөвлөгөөнд нэгжээс тусгуулах ажлыг оновчтой төлөвлөх, хэрэгжилтийн ахиулахтай холбоотой нэгжийн удирдлагууд хяналт тавьж ажиллах;

Яамны төрийн захиргааны удирдлагын газарт:

1. Төлөвлөгөөний зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу бичсэн хэрэгжилтийг нягтлан уншиж, нотлох баримтын хамтаар Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид өгч хэвших;
2. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин давтагдах шинжтэй, байнгын үргэлжилдэг ажлаас илүүтэйгээр үр дүнд хүрэх ажлыг оруулах талаар бусад нэгжүүдэд зөвлөмж өгөх;

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

--o0o—